

## ТАНИЛЦУУЛГА

### *Любляна-Гаагийн конвенцын төслийн тухай*

Төрлөөр устгах гэмт хэрэг, хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг болон дайны гэмт хэрэг нь олон улсын эрүүгийн эрх зүйд хамгийн ноцтой гэмт хэргийн төрөлд тооцогддог. Эдгээр гэмт хэргийг мөрдөн шалгах, хянан шийдвэрлэх, гэмт этгээдийг шийтгэх, улс хоорондын эрх зүйн туслалцааны хамтын ажиллагааг сайжруулах, гэмт этгээдийг шилжүүлэн өгөх олон талт эрх зүйн баримт бичиг байгуулахыг эрмэлзэж байна.

Энэ асуудлаар шинжээчдийн анхны уулзалтыг Нидерландын Хаант Улсын Доорн хотноо 2017 оны 10 дугаар сарын 16-19-ний өдрүүдэд зохион байгуулж, олон улсын онц ноцтой гэмт этгээдийг мөрдөн шалгах, шилжүүлэн өгөх, эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх орчин хангалтгүй буюу хуучирсан гэсэн дүгнэлтэд хүрсэн байдаг. Үүнийг шийдвэрлэх хамгийн үр дүнтэй арга бол олон талт шинэ гэрээ буюу Төрлөөр устгах гэмт хэрэг, хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг болон дайны гэмт хэргийг мөрдөн шалгах, хянан шийдвэрлэх олон улсын хамтын ажиллагааны тухай конвенц (Convention on International Cooperation in the Investigation and Prosecution of the Crime of Genocide, Crimes against Humanity and War Crimes) байгуулах гэж үзсэн.

Энэхүү конвенц байгуулах санаачилгыг Монгол Улс 2017 оноос дэмжиж ирсэн бөгөөд Бельги, Нидерланд, Словени, Аргентин Улс, Сенегал Улсын хамт конвенцын санаачилгыг урагшлуулах зорилготой Үндсэн бүлгийн гишүүнээр ажиллаж байна.

Конвенцын урьдчилсан төслийг Үндсэн бүлгийн гишүүд боловсруулж, 2019 оны 03 дугаар сарын 11-14-ний өдрүүдэд Нидерландын Гааг хотноо болсон 2 дахь бэлтгэл хурал (2<sup>nd</sup> Preparatory Meeting)-аар хэлэлцүүлж, дэмжигч орнуудаас ирүүлсэн саналыг тусган, 2019 оны 09 дүгээр сарын 06-ны өдрийн Үндсэн бүлгийн өргөтгөсөн хуралдаанаар хэлэлцэж, шаардлагатай нэмэлт өөрчлөлтийг оруулсан.

Үндсэн бүлгийн 2019 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн ээлжит хурал, 2019 оны 10 дугаар сарын 23-ны өдөр “Стратегийн уулзалт”-ыг зохион байгуулж, дэмжигч болон НҮБ-ын гишүүн бусад орнуудад конвенцын шинэ төслийг танилцуулсан.

Нидерландын Гааг хотноо 2020 оны 01 дүгээр сарын 27-29-ний өдрүүдэд зохион байгуулсан “Олон улсын онц ноцтой гэмт хэрэгтэй тэмцэх олон улсын конвенц” байгуулах санаачилгын “Албан бус зөвлөлгөөн”, 2020 оны 02 дугаар сарын 20-ны өдөр мөн Гааг хотноо болсон Үндсэн бүлгийн уулзалтаар конвенцийн төсөл, Дипломат Бага хурлын дэг, зохион байгуулалтын асуудлыг тохирсон.

Хүчин төгөлдөр үйлчилж буй “Төрлөөр устгах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, тийм хэрэг үйлдэгчдийг шийтгэх тухай конвенц”-д эрх зүйн туслалцаа үзүүлэх, гэмт этгээд шилжүүлэн өгөх тухай ойлголт хязгаарлагдмал байдаг.

“Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг НҮБ-ын конвенц” болон “Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхийн эсрэг конвенц”-д эрх зүйн туслалцаа, гэмт этгээдийг шилжүүлэн өгөх асуудлыг тусгасан боловч зөвхөн эдгээр конвенцод заасан гэмт хэрэгт хамаардаг.

Иймд төрлөөр устгах гэмт хэрэг, хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг, дайны гэмт хэрэгтэй тэмцэхэд эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх, гэмт этгээд шилжүүлэн өгөх тухай олон талт шинэ гэрээ байгуулах шаардлагатай гэж үзэж, энэхүү санаачилгыг өдгөө нийт 80 гаруй улс дэмжээд байна.

Конвенцын төслийг 2020 оны 06 дугаар сард Словени Улсын Любляна хотноо зохион байгуулахаар төлөвлөсөн Олон улсын дипломат бага хурлаар батлах байсан. Гэвч дэлхийн нийтэд тархсан цар тахлын улмаас бага хурлыг хойшлуулж, 2023 оны 05 дугаар сарын 15-26-ны өдрүүдэд Любляна хотноо болсон бага хурлаар “Төрлөөр устгах гэмт хэрэг, хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг, дайны гэмт хэрэг болон олон улсын бусад гэмт хэргийг мөрдөн шалгах, хянан шийдвэрлэх асуудлаар олон улсад хамтран ажиллах тухай Любляна-Гаагийн конвенц”-ын төслийг батлаад байна.

Уг конвенцын төслийг Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн хуралдаанаар хэлэлцэн дэмжээд Монгол Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороотой зөвшилцөхөөр шийдвэрлэсэн болно.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР